



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 4/186

Мандалговь

“Өлзийт сумын ЕБС-ын албан хэрэгцээнд
автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Өлзийт сумын ЕБС-ын албан хэрэгцээнд автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Х.Анхбаяр (Хот тохижуулах газрын дарга)

Гишүүд:

Т.Мөнхбаяр (Иргэний төлөөлөл)

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)

Г.Жавзмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Х.Анхбаяр)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060742